

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Гэр бүлийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын
төслийн талаар

Гэр бүлийн тухай хууль нь хувийн эрх зүйн асуудлуудыг зохицуулж байгаа суурь хуулиудын нэг бөгөөд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль 1999 онд батлагдсан. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн эрх зүй нь хувийн эрх зүйн суурь харилцаа байдлаар олон улсад тодорхойлогдож байна.

Гэр бүлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд тус хуульд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гэр бүлийн харилцаанд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн гэхээс илүүтэй салбарын харилцааг зохицуулсан буюу бусад хуулийн шинэчлэлийг дагалдан оруулсан өөрчлөлт байна.

Монгол Улсын хувьд хууль батлагдаж байсан үе буюу 1999 оноос хойш гэрлэх, гэрлэлт цуцлах, хүүхдийн эрх, хууль ёсны эрх ашиг хөндөгдөх, зөрчигдөх, сэргээх зэрэг харилцаа ихсэж байгаа бөгөөд үүнээс үүсэх үр дагаврыг төдийлөн нарийвчлан зохицуулаагүй байна.

Тухайлбал, Монгол Улсад гэр бүлийн маргааныг оновчтой шийдвэрлэх, гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал нэн чухал болоод байна. Шүүхийн шийдвэрийн тоо, баримтаас дурдвал 2020 онд 53678, 2021 оны эхний хагаст 20602 иргэний хэрэг шийдвэрлэснээс Гэр бүлийн тухай хуулиар 2020 онд 4732, 2021 оны эхний хагаст 2085 хэрэг шийдвэрлэсэн нь нийт хэргийн 10.1 хувийг эзэлж байсан байна.¹ Түүнчлэн, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шинэчилсэн мэдээллээр, 2021 онд 45444 иргэний хэрэг шийдвэрлэснээс Гэр бүлийн тухай хуулиар 4690 буюу нийт иргэний хэргийн 10.3 хувийг, 2022 онд нийт шийдвэрлэгдсэн 57633 иргэний хэргийн 6263 буюу 10.8 хувийг, 2023 онд шийдвэрлэгдсэн нийт 63407 иргэний хэргийн 5913 буюу 9.3 хувийг Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэрэг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 5 жилийн дундаж нийт иргэний хэргийн 10.1 хувь байна.

¹ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн тайлан. УБ., 2020. 2021 оны эхний хагас жил.


Зураг 1.



Жилд гэрлэлт 6.6 хувиар, гэрлэлт цуцлалт 1.0 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 2.

Шүүхийн шийдвэрийн статистик



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэл

Гэрлэлт дуусгавар болох харилцаанд нэн тэргүүнд хүүхдийн эрх ашиг хөндөгддөг боловч Зураг 2-т харуулсан шүүхийн шийдвэрийн графикаас харахад хүүхдийн тэтгэлгийг гэрлэлт цуцлалттай нь ч хамт шийдээгүй тохиолдол их байна. Тухайлбал, 2021 онд гэрлэлт цуцлуулах маргаан 2823 байхад үүнээс салангид 1297 хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан байжээ.

Монгол Улс 595 олон талт гэрээнд нэгдэн орсноос гэр бүлийн харилцаа, гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрхийг ханган хамгаалахаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Сайн дурын

үндсэн дээр гэрлэх болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц зэрэгт нэгдэн орж, соёрхон баталжээ.

Бусад улсын жишгээс үзэхэд, гэр бүлийн хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалтыг боловсронгуй байдлаар, түүнчлэн тээгч эхээр хүүхэд тээлгэх, зохиомлоор үр суулгах гэх зэрэг шинэлэг асуудлуудыг хууль тогтоомжоороо зохицуулж байна.

Иймд гэр бүлийн харилцааг олон улсын жишигт нийцүүлэх, шинээр үүсэж байгаа харилцааг зохицуулах, орхигдсон буюу хийдлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсрууллаа. Ингэхдээ хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэй, эсхүл бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан болон хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмыг баримталлаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа Чех, Польш, ОХУ, Исланд, Шинэ-Зеланд, БНСУ, Япон, ХБНГУ, БНХАУ, Канад, Финлянд зэрэг улсуудын гэр бүлийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Монгол Улсын шүүхийн статистик тоо, судалгаанд үндэслэсэн болно.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 11 бүлэг, 88 зүйлтэй байна. Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан доор танилцуулъя.

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

Хуулийн төслийн нийтлэг үндэслэлд тус хуулийн зорилт, хэрэглэх хууль тогтоомж, гэр бүлийн харилцааны зарчим, нэр томъёоны тайлбарыг тусгалаа.

Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж болохын хувьд тогтвортой, хэвийн харилцаатай байхад нийгмийн олон талын хүчин зүйлүүд ихээхэн нөлөөтэй.² Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 11-д “Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” гэж заасан нь гэрлэлт бүртгэхээс цуцлах хүртэлх үе шатанд төрийн байгууллагууд гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалж, үүрэг хүлээж, ажиллахыг баталгаажуулсан. Иймд хуулийн төслийн зарчим хэсэгт хуулийн төслийг хэрэглэхдээ эмзэг талын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илүү хамгаалах агуулгаар “Төр хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэй, эсхүл бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаална.” гэж тусгалаа.

Энэ хүрээнд мөн эцэг, эхийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор эцэг, эх хүүхдийг биеийн болон оюун санааны хувьд эрүүл өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалахаар тусгалаа. Мөн хүүхдийг гэр бүлийн орчинд өсгөн хүмүүжүүлэх зарчмыг тусгасан.

² Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн ТББ, Улаанбаатар хотод гэр бүл, өсвөр насны хүний хэргийн дагнасан шүүх байгуулах тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан УБ, 2019 он (хэвлэгдээгүй тайлан.)

Түүнчлэн энэ хуульд хэрэглэгдэх нэр томъёог энгийн, ойлгомжтой болгох зорилгоор нэр томъёоны тайлбарт асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхэд, бүтэн өнчин хүүхэд, сонирхогч тал гэх зэргийг нэмж тайлбарлалаа.

Хоёрдугаар бүлэг

Гэрлэх нөхцөл, гэрлэлтийн бүртгэл, гэрлэгчдийн эрх, үүрэг

Монгол Улсын хэмжээнд 2016 онд 16,8 мянган хос, 2017-2019 онд жилдээ 20,0-21,0 мянган хос гэрлэлтээ бүртгүүлж байсан бол 2020, 2021 онд тус бүр 14,2 ба 16,1 мянга болж буурчээ. Түүнчлэн 2016 онд 4,0 мянган гэр бүл гэрлэлтээ цуцалсан бол 2020, 2021 онд тус бүр 3,3, 3,4 мянга болж буурчээ.

Харин 2022 онд 17694 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4515 гэрлэгчид гэрлэлтээ цуцлуусан байна. 2023 онд 17408 хос гэрлэлтээ бүртгүүлж, 4776 хос гэрлэлт цуцлуулсан, 2024 онд 14225 хос гэрлэлт бүртгүүлсэн бол 4463 хос гэрлэлт цуцлуулсан байна.

Эндээс нийт гэрлэлтийн бүртгэлд оногдох гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ 27-33 хувь байна.

Гэрлэх нөхцөлд шинээр Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан.

Гэрлэгч хосуудад удам зүйн шинжилгээ хийж ураг төрлийн гурав болон түүнээс дээш үеийн үеэл, хаяал, бүл, өвөг, удмуудыг тодорхойлох бөгөөд үүнийг хийхэд генетик генологийн харьцуулах өгөгдөл, мэдээллийн сан шаардлагатай байдаг байна.

Бусад улсад генетик генологийн сан бий болгон суурь судалгааг хэдийнээ хийж практикт хэрэглээнд ашиглаж байна. Тухайлбал, Исланд Улсад 1703 онд анхны бүртгэлжүүлэлт эхэлсэн бөгөөд тогтвортой, тодорхой байдлаар удмын хэлхээг хадгалсаар ирсэн. Исланд Улс нийт иргэдийнхээ генийн мэдээллийг хадгалж, холбогдох судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг генологийн санг ажиллуулж байна. Тухайн генологийн судалгааны байгууллага нь цахим мэдээллийн нээлттэй сантай бөгөөд тус сангаас хосууд, эсхүл иргэд удам зүйн харилцан хамаарлын мэдээллээ хялбар байдлаар авч болдог байна.

Мөн БНХАУ хүн амын удмын санг зохицуулдаг хуультай байна. БНХАУ-ын Хүний генетикийн нөөцийн менежментийн тухай хууль /Regulation on the Management of Human Genetic Resources/ нь 2019 онд батлагдсан ба нийт 6 бүлэг 47 зүйл заалттай.³ Тус хуулийн агуулга нь хүний генетик нөөцийг зөв зохистой хамгаалах, зохистой ашиглах, нийгмийн эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдал, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байна.

Түүнчлэн Удмын сангийн аюулгүй байдлын талаарх харилцааг Эрүүгийн хуулиар 23 улс, Иргэний хуулиар 7, Гэр бүлийн хуулиар 9, бие даасан хуулиар 4 улс зохицуулж байна.⁴

³ Парламентын судалгааны эмхэтгэл 32-р боть, Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа, УБ., 2021 он, 366 дахь тал.

⁴ Мөн тэнд, 367 дахь тал.

“Монголын хүн амын генетик тогтоц, уур амьсгалын хахиршилт ба өвчлөл, нас баралтын хам холбоог газар зүйн байршлаар мөшгөн судлах нь” судалгаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн амын 6.1 хувь нь цус ойртсон байх магадлалтай⁵ гэсэн нь Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал тулгамдаж байгааг харуулж байна. Энэ нь гэрлэхийг хүсэгчид хоорондоо төрөл, садангийн холбоотой эсэхээ мэдэх боломжийг хангах зохицуулалт бүрдээгүйгээс тодорхой хэмжээнд шалтгаалж байна гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурал 2022 онд “Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” 01 дүгээр тогтоолыг баталсан. Тус тогтоолд Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт технологи бүхий генетикийн лаборатори, генийн сан байгуулах асуудлыг судлан шийдвэрлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Иймд цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор садан, төрлийн хүмүүсийн хоорондын гэрлэлтийг тодорхой хэмжээнд хязгаарлаж буюу гэрлэхийг хүсэгчид ДНХ-ийн шинжилгээнд хамрагдах боломжийг төсөлд тусгаж, хэрэв гэрлэсний дараа удамших сэтгэцийн өвчтэй байсныг нь нөгөө тал мэдсэн бол гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох эсэх асуудлыг тухайн талын гаргасан нэхэмжлэлээр шүүх шийдвэрлэхээр зохицууллаа.

Түүнчлэн гэрлэхийг хүсэгчдийн заавал өгөх эрүүл мэндийн шинжилгээний хариуг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасантай уялдуулан мэдээлэх асуудлыг тусгалаа.

Гэрлэгчдийн эрх, үүрэг

Гэрлэлт цуцлах шалтгааны дийлэнх хувийг гэрлэгчид хоорондын таагүй харилцаа эзэлсэн хэвээр байхад гэр бүлээс гадуурх харилцаа 2 хувиас 20 хувь болж эрс өсчээ.

Тодруулбал, шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2017 онд шийдвэрлэсэн гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс 50 шийдвэрийг түүвэрлэж,⁶ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг судлан үзэхэд, таарамжгүй харилцаа 38 буюу 76 хувь, гэр бүлээс гадуурх харилцаа тогтоосон 1 буюу 2 хувь, архидалт 6 буюу 12 хувь, тусдаа амьдарч байгаа 4 буюу 8 хувь, гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2 хувийг тус тус эзэлж байна.

Харин 2022 оны хувьд, гэрлэлт цуцлах болсон шалтгаанд таарамжгүй харилцаа 32 буюу 64 хувь, архидалт буюу 10 хувь, тусдаа амьдарч байгаа 2 буюу 4 хувь, гэр бүлээс гадуурх харилцаа 10 буюу 20 хувь, мөн гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2 хувийг тус тус эзэлсэн болно.

Тэгвэл гэрлэлт цуцлах болсон шалтгааны хоёрдугаарт орж байгаа бөгөөд эрс нэмэгдэж байгаа шалтгаан болох гэр бүлээс гадуурх харилцааны талаар БНСУ-д хэрхэн зохицуулдаг талаар дурдая.

⁵Э.Энхмаа, Монголын хүн амын генетик тогтоц, ур амьсгалын хахиршилт ба өвчлөл, нас баралтын хам холбоог газар зүйн байршлаар мөшгөн судлах нь, Улаанбаатар хот, 2010 он

⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл XIII боть 2023 он, Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ С.Сүхбаатар, Б.Энх-Амгалан, Х.Санчир 2022, хуудас 134-135.

БНСУ-ын Иргэний хуульд зааснаар гэрлэгчийн зүй бус үйлдэл нь гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах үндэслэл болох бөгөөд зүй бус үйлдэлд гэр бүлээс гадуур харилцааг багтаан ойлгодог. Шүүхээс гэр бүлээс гадуур харилцааны улмаас гэрлэлтийг цуцлах тохиолдолд гэр бүлээс гадуур харилцааг бий болгосон талаас мөнгөн төлбөр оногдуулах жишгийг тогтоосон байна.

Гэрлэгчдийн хэн нэг нь гэр бүлээс гадуур харилцаанд орсон үйлдэл нь зүй бус үйлдэлд тооцогдож гэр бүл цуцлах хууль зүйн үндэслэл болохоос гадна нөгөө гэрлэгчийн сэтгэл санаанд хохирол учруулсан гэж үзэн түүнд нь тохирсон хариуцлага хүлээлгэхээр зохицуулж байна.

Иймд хуулийн төслөөр Гэр бүлийн тухай 1999 оны хуульд заасан гэрлэгчдийн эрх, үүргийг нарийвчилсан бөгөөд шинээр нэмсэн болно.

Гуравдугаар бүлэг

Гэрлэлт дуусгавар болох, цуцлах, хүчин төгөлдөр бус гэж тооцох, сэргээх, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, гэрлэлттэй адилтгах харилцаа

Гэрлэлт дуусгавар болох

Сүүлийн 5 жилийн хугацаа (2020-2024 оны эхний хагас)-нд Гэр бүлийн тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн 25,030 хэргийн 57,8 хувь буюу 14,477 хэрэг гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг шийдвэрлэсэн.⁷ Мөн 2010 онд гэрлэлт цуцалсан тоог 2021 оны тоотой харьцуулахад 58 хувиар өссөн байна. Иймд гэрлэлт цуцлалтаас үүсэх үр дагаврыг сайтар тооцох, гэрлэгчид болон хүүхдийн эрх, ашгийг хамгаалах зохицуулалтыг нарийвчлан зохицууллаа. Тухайлбал, гэрлэлт цуцлуулсан нь хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалах эцэг, эхийн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байхаар бөгөөд гэрлэлт дуусгавар болох үедээ хүүхдийн тэтгэлэг тогтоолгохоос татгалзсан хүсэлтийг шүүхэд гаргах эрхгүй байхаар тусгалаа.

Учир нь гэрлэлт дуусгавар болох харилцаанд нэн тэргүүнд хүүхдийн эрх ашиг хөндөгддөг боловч хүүхдийн тэтгэлгийг гэрлэлт цуцлалттай нь хамт шийдээгүй тохиолдол их байна. Тухайлбал, 2020 оноос 2024 оны эхний хагас жилийн байдлаар гэрлэлт цуцлуулах маргаан 25,030 байхад үүнээс салангид 10,938 хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан байжээ.⁸

Мөн хуулийн төсөлд гэрлэлт цуцлах тусгай журамд гэрлэгчид эвлэрэх боломжгүй, эсхүл гэрлэгчийн байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон, эсхүл тодорхой хугацаанд хамтран амьдраагүй нь тогтоогдсон бол **шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр** гэрлэлтийг цуцалж болохоор тусгалаа. Харин эхнэр нь жирэмсэн, эсхүл гурван насанд хүрээгүй хүүхэдтэй, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл хариуцагч нь хүндээр өвчилсөн, эсхүл хөдөлмөрийн чадвараа хагас, эсхүл бүрэн алдсан тохиолдолд хариуцагч гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шүүх хэрэгсэхгүй болгохоор тусгасан. Гэхдээ шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулахад эхнэр нь жирэмсэн, эсхүл гурван насанд хүрээгүй хүүхэдтэй,

⁷ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн албан бичгийн 1 дүгээр хавсралт.

⁸ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн албан бичгийн 1 дүгээр хавсралт.

эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл хүндээр өвчилсөн, эсхүл хөдөлмөрийн чадвараа хагас, эсхүл бүрэн алдсан нөхцөл байдал нь нэхэмжлэгчид хамааралтай бол шүүх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэж болно.

Хүйсийн өөрчлөлтийн улмаас гэрлэлт дуусгавар болохоор харин гэрлэлт дуусгавар болсонтой холбоотойгоор үүсэх бусад асуудал, тухайлбал хүүхдийн тэтгэлэг тогтоох, тэжээн тэтгэх, асран хамгаалах, эд хөрөнгө хуваах зэрэг асуудлыг шүүхэд хандан шийдвэрлүүлэхээр тусгалаа.

Гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцох

Түүнчлэн Монгол Улсад хүсэл зоригийн эсрэг гэр бүл болохыг завдсан гомдол, мэдээллүүд байдаг тул энэхүү үйлдлээр гэрлэлт бүртгүүлснийг эрх бүхий байгууллагаар нотлуулсан тохиолдолд гэрлэлтийг хүчингүйд тооцохоор зохицууллаа.

Гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцуулах нэхэмжлэлийн нэг тал нь эрх зүйн чадамжгүй хүн байх магадлал байдаг байна. Иймд гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж шүүхээр тооцуулах нэхэмжлэлд эрх зүйн чадамжгүй хүнийг төлөөлөх асуудлыг тусгасан.

Түүнчлэн гэрлэгчдийн хэн нэг нь хүчин төгөлдөр бус гэж тооцогдох үндэслэлийг нууж, эсхүл хууран мэхэлж гэрлэсэн гэрлэлт нь хүчин төгөлдөр бус тооцогдох тохиолдолд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болохоор зохицууллаа. Мөн гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос шалтгаалж гэрлэгчийн болон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хохирлыг буруутай этгээдээс шаардах эрхийг баталгаажууллаа.

Гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцсон ч тухайн гэрлэлтээс төрсөн, эсхүл үрчлэн авсан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй бөгөөд эцэг, эх хуульд заасан үүрэг, хариуцлага хүлээхээр, харин гэрлэгчдийн хооронд байгуулсан гэрлэлтийн гэрээ хүчин төгөлдөр бус болохоор зохицууллаа.

Түүнчлэн гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол уг гэрлэлтийг дахин сэргээхгүй байхаар зохицуулсан болно.

Гэрлэлт сэргээх

Хуульд заасан тохиолдолд гэрлэлт сэргээж болохоор, мөн үүний үр дагавар нь гэрлэлтийг анх бүртгүүлсэн өдрөөс тооцохоороор нэмж зохицууллаа.

Гэрлэлт цуцлахад хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн хувьд, 2018 онд өмнөх оноосоо 90 хэргээр олон буюу 9.4 хувиар, 2020 онд өмнөх оноосоо 286 хэргээр буюу 27 хувиар тус тус өссөн буюу жилээс жилд нэмэгдсэн үзүүлэлттэй байна.⁹ Сүүлийн үеийн мэдээллээр, 2020 онд 703, 2021 онд 1034, 2022 онд 2499, 2023 онд 3855 хүүхдийн тэтгэлэг тогтоолгох хэрэг шийдвэрлэгдсэн байгаа нь тэтгэлэг тогтоолгох нэхэмжлэл нэмэгдэж байгааг мөн адил харуулж байна.¹⁰

⁹Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

¹⁰ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн албан бичгийн 1 дүгээр хавсралт.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагад тусгасан эсэхээс үл хамаарч гэрлэлт цуцлах маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэмжийн асуудлыг давхар шийдэж байгаа эсэхийг авч үзвэл:

– 2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, 10 шийдвэр буюу 20 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй гаргасан байна.

– 2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан байна¹¹.

Иймд шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа тухайн гэрлэгчид хүүхэдтэй бол нэхэмжлэлийн шаардлагаас үл хамаарч хүүхдийн тэтгэлэг, хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг, хариуцлага, хүүхэдтэйгээ уулзах, хугацаа нөхцөлийг зэргийг хамтад нь шийдвэрлэх зохицуулалт тусгалаа. Мөн хүүхдийн тэтгэлэг тогтоолгохоос татгалзах эрх нэхэмжлэгчид байхгүй байхаар тусгалаа.

Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах

Гэрлэгчид буюу тэдгээрийн хэн нэгнийх нь хүсэлтээр шүүх гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа гэрлэлтийн гэрээ, эсхүл гэрлэлтийн гэрээ байгуулаагүй бол хууль тогтоомжид заасны дагуу гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийг хувааж, хуваарилна.

Гэрлэгчдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн харилцааг тогтвортой болгох, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор гэрлэлт цуцалснаас гэр бүлийн гишүүнд ногдох дундын эд хөрөнгийн хэсгийг тодорхойлоход гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс, түүнчлэн дундын эд хөрөнгөө зүй бусаар ашигласан, нуусан, гэр бүлийн хүчирхийлэл, үүргээ биелүүлээгүй гэрлэлт цуцалсан нь түүний буруутай үйлдлээс шалтгаалсан нь тогтоогдсон нөхцөлд шүүх Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэхээр тусгалаа.

Гэр бүлтэй адилтгах харилцаа буюу хамтран амьдрагч

Зарим улсад гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдарч байгаа харилцаа буюу (Defacto)-г хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна. Гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдрах хэлбэр нь эдийн засаг болон бусад хэрэгцээг хангах, гэр бүлийн зарим үүргийг гүйцэтгэдгээрээ гэр бүлийн төлөв байдалтай төстэй харилцаа гэж үздэг.

Тухайлбал, БНСУ-ын хуулиар гэр бүл болсныг хүлээн зөвшөөрөх хууль зүйн үндэслэл нь тус улсын Иргэний хуулийн 812.1-д заасны дагуу Гэр бүлийн

¹¹ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлснээр бий болохоор хуульчилсан байдаг. Шүүх энэхүү хуулийг практикт тайлбарлан хэрэглэхдээ дээрх хуульд заасны дагуу холбогдох бүртгэлд гэрлэлтийн байдлаа бүртгүүлээгүй боловч гэр бүлийн хэлбэрийг агуулан, цаашид гэрлэлтээ бүртгүүлэх зорилгоор нэг хаяг дээр хамтын хөрөнгө бий болгон амьдарч байгаа тохиолдолд гэр бүл болсон гэж үздэг байна.

БНСУ дээрх харилцаанаас үүсэх хууль зүйн үр дагаврын хувьд хамтын амьдралаа дуусгавар болгох тохиолдолд бусад гэр бүлийн нэгэн адил дундын өмчлөлийн эд хөрөнгөө эн тэнцүү хуваах, хүүхдийн эрхийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлдэг байна. Гэвч гэрлэлтээ бүртгүүлээгүй хосуудын хэн нэг нь нас барсан тохиолдолд хосуудын хамтын оролцооны үр дүнд бий болсон дундын эд хөрөнгийг үлдсэн хамтран амьдрагч нь эд хөрөнгө хуваах болон өв залгамжлалын аль ч хэлбэрээр өмчлөх боломжгүй байна.

Манай улсын хувьд Гэр бүлийн тухай хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгаагүй. Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд “энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс... нэгэн адил хамаарна” гэж хамтран амьдрагчдын талаар зохицуулсан.

2014-2022 оны хооронд эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй буюу хамтран амьдарч байх хугацаанд нь 22924 хүүхэд шинээр мэндэлсэн байна¹². Энэхүү тоо баримтаас үзэхэд хамтран амьдрах (Defacto) хэлбэр түгээмэл гэж үзэж байна. Манай улсын хувьд гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдарч байгаа хүмүүсийн эрх, үүргийг тодорхойлох цаашлаад эд хөрөнгө хуваах, хүүхэд асрамжлалын маргаан үүсэх тохиолдолд үүсэх үр дагаврыг зохицуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Иймд хуулийн төсөлд хамтын амьдрал дуусгавар болж, хамтран амьдрагч нарын эд хөрөнгийн маргааныг шүүх шийдвэрлэх үедээ хамтран амьдрагчдын гэрлэлтээ бүртгүүлэх зорилготой байсан эсэх, хэн нэг нь өөр хүнтэй гэрлэлтээ бүртгүүлээгүй байсан эсэх, таваас доошгүй жил тогтмол хамт амьдарсан эсэх, дундын эд хөрөнгө бий болгосон эсэх, нэг хаяг оршин суух хаягийн бүртгэлтэй эсэх нөхцөл байдлыг харгалзан хамтын амьдралыг гэрлэлттэй адилтган тооцохоор тусгасан. Харин хамтын амьдрал дуусгавар болоход бие биеэ тэжээн тэтгэх, өв залгамжлах эрх, үүрэг үүсэхгүй байхаар хуулийн төсөлд зохицууллаа.

Мөн энэ төрлийн харилцаанаас төрсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэг зохицуулалтыг тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэг Гэрлэлтийн гэрээ

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээний зохицуулалт анх Франц, Англи зэрэг улсаас үүсэлтэй гэж судлаачид үздэг ба эмэгтэйчүүдийн болон түүний садангийнханд гэрлэлтээс өмнөх хөрөнгийг захиран зарцуулах, өмчлөх, эсхүл ашиг орлогын хувь хүртэх эрхийг харилцан тохиролцон баталгаажуулах шаардлага үүсжээ¹³.

¹² О.Отгонтуяа, О.Амарсайхан. “Монгол улсын гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт” УБ., 2009. 60 дахь тал

¹³ Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхим.

Судалгааны илтгэлийн эмхтгэл. УБ., 2006. 41-44 дэх тал. Дам эшлэл

Гэрлэлтийн гэрээ нь гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох эд хөрөнгийг тодорхойлох, эд хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг иргэний хуульд нийцүүлэн байгуулах иргэний эрх зүйн гэрээ¹⁴ юм. Нөгөөтэйгүүр, Англо-саксоны эрх зүйн бүлтэй зарим улсад гэрлэлтийн гэрээгээр эд хөрөнгийн харилцааг зохицуулахаас гадна, мөн амины харилцааг зохицуулж байгаа жишиг байна. Гэрлэлтийн гэрээг БНСУ, Япон, ОХУ, ХБНГУ зэрэг улсууд хууль тогтоомжоороо зохицуулж байна.

Манай улсын хувьд 1926 оны анхны Иргэний хуульд “Эр, эм хоёр аливаа хогшлын тухай засварт хууль ёсоор гэрээ, хэлэлцээр байгуулж болмой”¹⁵ гэж заасан нь тухайн үед гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ байгуулах эрх зүйн боломж байсныг гэрчилж байна. Харин үүнээс хойших 1963, 1994 оны Иргэний хууль, 1956, 1973 оны Гэр бүлийн тухай хуулиудад энэ талаар зохицуулалт байгаагүй байна.

Харин 2002 оны Иргэний хуульд гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээний зохицуулалтыг тусгасан байна. Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.2 дахь хэсэгт “Гэрлэгчдийн хөрөнгийн эрхийн зарим харилцааг гэрээгээр зохицуулж болно” гэж, мөн хуулийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсэгт “Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болно” гэж тус тус заасны дагуу гэрлэгчид хоорондоо гэрээ байгуулах боломж байгаа хэдий ч гэрлэгчид төдийлөн түгээмэл байгуулахгүй байна. Өөрөөр хэлбэл, гэрлэлтийн гэрээ гэх нэр томъёог хэрэглэдэггүй, мөн энэхүү гэрээг Гэр бүлийн тухай хуульд тухайлан тодорхой тусгаагүй байгаа нь түүнийг түгээмэл хэрэглэхэд саад учруулж байна гэж үзэж байна.

Иймд хуулийн төсөлд гэрлэлтийн гэрээний талаар шинэ зохицуулалтыг тусгасан бөгөөд тус гэрээгээр гэрлэгчдийн эрх ашгаа хамгаалах, гэр бүлийн харилцаанд мөн гэрлэлт цуцалсан тохиолдолд эд хөрөнгийн эрхээ хамгаалах боломжийг бий болгосон. Гэрээгээр зохицуулагдах асуудлуудаас гадна, хууль тогтоомжид заасан зайлшгүй биелүүлэх шаардлагатай үүргээ хэрэгжүүлэхгүй байх нөхцөлийг гэрээнд тусгахыг хориглохоор тусгаад байна. Тухайлбал, гэрлэгчид бие биеэ, насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч сургуульд сурч байгаа 21 хүртэлх насны, эсхүл хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх, сурах эрхийг хангах үүргээс чөлөөлсөн, эсхүл хязгаарласан агуулгыг гэрлэлтийн гэрээгээр тусгахгүй байхаар зохицуулсан.

Мөн гэрлэгчид гэрлэлтийн гэрээгээр эд хөрөнгийн эрх үүсэх, шилжүүлэх, дуусгавар болох, хязгаарлахаар зохицуулсан, эсхүл ийм харилцаа агуулсан бол зохих журмын дагуу хөрөнгийн төрлөөс хамаарч бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх зохицуулалтыг нэмж тусгасан. Түүнчлэн гэр бүлийн гишүүд, гэрлэгчид эд хөрөнгө эзэмших, өмчлөх эрхийг Иргэний хуульд заасантай уялдуулж баталгаажуулсан. Ингэснээр гэрлэгчдийн үл хөдлөх эд хөрөнгийг тодорхой хэмжээнд хамгаалах нөхцөл бүрдэнэ. Гэрлэлтийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрд бүртгүүлэх шаардлагыг хуульчилсан.

¹⁴ С.Нарангэрэл, “Хууль зүйн нэвтэрхий толь бичиг”, УБ 2021 он, 101-р тал.

¹⁵ Сүхбаатар З. Оюундэлгэр П. Монгол Улсын Иргэний хуулиуд, нэмэлт өөрчлөлтүүд (1926, 1952, 1963, 1994, 2002). УБ., 2002., 27 дахь тал.

Гэрлэлтийн гэрээний зохицуулалттай холбогдуулан Иргэний хууль болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

Тавдугаар бүлэг
Хүүхдэд нэр, эцэг /эх/-ийн нэр, овог өгөх,
эцэг /эх/-ийг тогтоох

Бусад улсын туршлагаас үзэхэд, тээгч эх, донорын зохицуулалтыг гэр бүлийн эрх зүйн хүрээнд зохицуулж эхэлсэн байна. Тухайлбал, Чех, ОХУ-ын хуулиар нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байна. Кембрижийн Их сургуулиас тээгч эхээр хүүхэд тээлгэж төрүүлэх харилцааг хүлээн зөвшөөрдөг болон зөвшөөрдөггүй орнуудын судалгааг¹⁶ гаргасан бөгөөд судалгаанаас үзэхэд ихэнх улс орнууд ашгийн бус хүмүүнлэгийн зорилгоор тээгч эх болох, тээгч эхээр хүүхэд тээлгэж төрүүлэх харилцааг хуульчилсан бол Хятад, Герман, Итали, Япон, Франц, Турк зэрэг орнууд хүлээн зөвшөөрдөггүй байна.

Манай улсын нөхөн үржихүйн эрүүл мэндийг асуудлыг Донорын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалтад "донор бэлгийн эс" гэж өөр хүний эр, эм бэлгийн эсийг", мөн зүйлийн 3.1.16 дахь заалтад "'тээгч эх" гэж бусдын үр хөврөлийг тээж, хүүхэд төрүүлэх эмэгтэй", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт "Эрүүл мэндийн шалтгаанаар өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон эмэгтэйг тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрнө.", мөн зүйлийн 18.7 дахь хэсэгт "Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах, тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, талуудын хооронд байгуулах гэрээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж тус тус тусгасан байна. Гэвч энэхүү аргыг ашиглах зохицуулалт, үүнээс үүсэх үр дагавар, мөн төрсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалт байхгүй байна. Тухайлбал, энэхүү аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох зохицуулалт байхгүй байна.

Иймд тээгч эх, үрийн донор гэх мэт нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж төрсөн хүүхдийн эцэг, эхээр тогтоох асуудлыг шүүхээр шийдвэрлэхээр тусгасан.

Зургадугаар бүлэг
Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,
эцэг, эхийн эрх, үүрэг, хариуцлага

2021 оны байдлаар гэр бүлийн орчноос байнга болон түр хугацаагаар тусгаарлагдаж асрамж, халамжийн газарт 1069 хүүхэд амьдарч байгаа бөгөөд хараа хяналтгүй 97, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 92, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 278 хүүхэд байна. Энэ нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг шаардах боломжийг хангах, эцэг, эхийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох зохицуулалт шаардлагатайг харуулж байна.

¹⁶ Улсын их хурлын тамгын газрын Судалгааны эмхэтгэл "Тээгч эхээр хүүхэд тээлгэж, төрүүлэх харилцаа: Монгол улс болон гадаад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалт" харьцуулсан судалгаа 2017 онд, хуудас 303 бүтэн,

Зөрчлийн тухай хуулиар хүүхдийн эсрэг зөрчил оногдуулсан нийт зөрчлийн хэргийн тоо:

- 6.20.1.4 “хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох” заалтаар 2021 онд 20 иргэнд, 2022 онд 14, 2023 онд 8 зөрчил, нийт 42 зөрчил;
- 6.20.7 “Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” заалтаар 2021 онд 20, 2022 онд 35, 2023 онд 8 зөрчил, нийт 63 зөрчил;
- 6.20.2.3 “хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” заалтаар 2021 онд 2, 2022 онд 10, 2023 онд 5 зөрчил, нийт 17 зөрчил.

Дээрх тоо, статистикаас үзэхэд хүүхдийн эсрэг үйлдсэн зөрчил нэмэгдсэн байна.

Хуулийн төсөлд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан ба хүүхдээс тусдаа амьдарч байгаа эсэхээс үл хамааран хүүхдийн өмнө хүлээх эцэг, эхийн үүрэг хариуцлагыг coparentalité буюу хамтын хүлээх зарчмыг баримтлан тодорхой тусгасан.

Хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүргийг нэмэгдүүлэх зорилгоор Зөрчлийн тухай хуульд хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах үүргээ удаа дараа хэрэгжүүлээгүй болон уулзах эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад бол зөрчлийн шийтгэл оногдуулах зохицуулалтыг нэмж тусгалаа.

Хүүхдийн эд хөрөнгийн эрх

Канад, Литва, Финлянд зэрэг улсуудад хүүхдийн өөрийн хөрөнгийг гэр бүлийн дундын хөрөнгөөс зааглан тодорхойлж, асран хамгаалагч харгалзан дэмжигч нь тодорхой хязгаартай эсхүл зөвшөөрлийн дагуу захиран зарцуулахаар хуульчилсан байна. Тухайлбал, Литвад хүүхдийн хөрөнгийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь узуфрукт эрхээр захиран зарцуулж байна. Иймд хүүхдийн эд хөрөнгөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зарцуулах эрхийн зохих хэмжээнд хязгаарлалтыг зохицуулсан бөгөөд холбогдох зохицуулалтыг Иргэний хуульд өөрчлөлт оруулж тусгалаа. Тодруулбал, хүүхдийн эд хөрөнгийн хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэх зарцуулах, зөрчигдсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах хугацааг нэмж тусгалаа.

Эцэг, эх байх эрхийг хасах хязгаарлах

2016-2021 оны хугацаанд эцэг, эх байх эрхийг хассан 81 шүүхийн шийдвэр гарсан нь харьцангуй өндөр үзүүлэлт бөгөөд шүүхийн шийдвэрийн үр дүнд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл үүсэж байна. Иймд үүнээс үүсэх үр дагаврыг тооцоолох, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, эцэг, эх байх

эрхийг хассан тохиолдолд түүнийг буцаан сэргээх, эсхүл эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарлах зэрэг оновчтой зохицуулалтууд хангалтгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын гишүүн улсууд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллага, шүүхээс зохих хууль журмыг үндэслэн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хүүхдийг хүсэл зорилгийнх нь эсрэг эцэг, эхээс нь салгахгүй байх үүрэг хүлээнэ гэж заажээ. Энэ төрлийн шийдвэрийг эцэг, эх хүүхэдтэйгээ хэрцгийгээр харьцах, анхаарал халамжгүй орхих зэрэг тохиолдолд гаргадаг байна. Мөн ХБНГУ-ын Үндсэн хуулийн дагуу эцэг, эх байх эрх нь чухал үндсэн эрхүүдийн нэг учраас эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах асуудалд өндөр босго, шалгуурыг тавьдаг. Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хүүхдийг гэр бүлээс нь хураан авч өөр гэр бүл, хүмүүс, байгууллагад шилжүүлэхээс өмнө хүүхдийн сайн сайхны төлөө ямар арга хэмжээ авч болох цаашид хэрхэх талаар нухацтай судалж үздэг байна. Үүний дараа эцэг, эхийн эрхийг хязгаарлах, хасах эсэх талаар шийдвэр гаргадаг байна.

Иймд эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах үндэслэл, нөхцөл, түүнээс үүсэх үр дагаврыг ялгаж, жигдрүүлж, дахин найруулсан. Тухайлбал, хязгаарласан асуудлыг “хүчингүйд тооцох” гэснийг “дуусгавар болгох” гэж өөрчилж, тэргүүн ээлжинд хязгаарлах арга хэмжээ авах, харин хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн тохиолдолд эцэг, эх байх эрхийг нь хасах шийдвэр гаргадаг байхаар хуулийн төсөлд тусгалаа. Түүнчлэн эцэг, эх байх эрхийг хязгаарласан, хассан тохиолдолд эрхийг буцаан сэргээхдээ сургалтад заавал хамрагдсан байхаар тусгалаа.

Долдугаар бүлэг

Тэжээн тэтгэх үүрэг, тэжээн тэтгүүлэх үүрэг

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн хувьд, 2018 онд өмнөх оноосоо 90 хэргээр олон буюу 9.4 хувиар, 2020 онд өмнөх оноосоо 286 хэргээр буюу 27 хувиар тус тус өссөн буюу жилээс жилд нэмэгдсэн үзүүлэлттэй байна.¹⁷

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагад тусгасан эсэхээс үл хамаарч гэрлэлт цуцлах маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэмжийн асуудлыг давхар шийдэж байгаа эсэхийг авч үзвэл:

– 2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, 10 шийдвэр буюу 20 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80% нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй гаргасан байна.


– 2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй гаргасан байна¹⁸.

¹⁷ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

¹⁸ Мөн тэнд, 19 дэх тал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээллээс үзэхэд, 2022 онд 14885 тэжээн тэтгүүлэгч хүүхдэд холбогдох 12184 гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан байна. Мөн хүүхдийн тэтгэлгийн 60 гаруй хувь нь огт төлөгддөггүй бөгөөд үүнд ажилгүйдэл, ядуурал, иргэдийн төлбөрийн чадваргүй байдал зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Үүнээс гадна, тогтоогдсон тэтгэлгийн хэмжээ бага байгаагаас хүүхдийн наад захын хэрэгцээ хангагдахгүй байх, хоол тэжээлийн доройтолд орох зэргээр хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөн бойжих, сурч боловсрох эрх зөрчигдөж байна.

Зураг 4.Хүүхдийн тэтгэлэг төлөлт



Манай улсын хувьд тэтгүүлэгч буюу хүүхдийн амьдарч байгаа бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшний хэмжээнээс тодорхой хувиар тооцон тэтгэлгийн хэмжээг тогтоож байна. Иргэд, олон нийтийн зүгээс хүүхдийн тэтгэлгийн хэмжээ хэт бага буюу хүүхдийн хэрэгцээнд хүрэлцэхгүй байх, нөгөө талаас тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдахгүй байна гэсэн шүүмж гарч байна.

ХБНГУ, Англи, БНСУ, Япон зэрэг улсын жишгээс үзэхэд, тэтгэлэг тогтоох тусгай аргачлалтай бөгөөд тэтгэлгийн хэмжээг хүүхдийн нас, амьжиргааны өртөг, зардал зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан тэтгэлэг төлөгчийн орлого, нөхцөл байдалтай уялдуулж тэтгэлэг авагч тус бүрд өөр өөр байдлаар тогтоож байна. Мөн хүүхдийн тэтгэлгийн харилцааг зохицуулсан гэрээ байгуулж болохоор зохицуулсан байна.

Иймд “frequent, continuing and meaningful” зарчмын дагуу шүүх гэрлэлт цуцлах шийдвэрийг гаргахдаа нэхэмжлэлийн шаардлагад дурдсан эсэхээс үл хамаарч хүүхдийн тэтгэлгийн асуудлыг заавал хамтад нь шийдвэрлэхээр зохицуулсан. Мөн гэрлэлт цуцлалт, дуусгавар болсон харилцаанд хүүхэд болон гэр бүлийн гишүүдийн авах тэтгэлгийн хэмжээг өөрчилж тэтгэлэг авагч болон тэтгэлэг төлөгчийн нөхцөл байдалтай уялдуулж эрх бүхий байгууллагаас батлах аргачлалын дагуу шүүх шийдвэрлэхээр шинэ зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд төлбөр төлөгч хөрөнгө, орлогогүй, хөдөлмөр эрхлэх боломжтой боловч хөдөлмөр эрхэлдэггүйн тогтоогдсон бол төлбөр төлөгчийн мэдээллийг харьяалах хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шилжүүлж, хамтран ажиллах зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр

тэтгэлэг төлөгчид хөдөлмөр эрхлэх боломж олгож, хүүхдийн тэтгэлгээ төлөх нөхцөл бүрдүүлэх юм.

Наймдугаар бүлэг Асран хамгаалах, харгалзан дэмжих

Улсын хэмжээнд 21 байгууллагын 31 халамж, асрамжийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 26, Дархан-Уул аймагт 2, Дорнод аймагт 1, Орхон аймагт 1, Өвөрхангай аймагт 1 төв ажиллаж байна. Эдгээр төвүүдээс 3 төв нь улсын төсвөөс, 28 төв олон улсын болон төрийн бус байгууллага, хувь иргэний санхүүгийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Асрамж, халамж төвүүдэд 2020 онд 1069, 2021 онд 1031, 2022 оны байдлаар 1035 хүүхэд, залуус өсөж, хүмүүжиж байна. Үүнээс 526 нь эрэгтэй, 505 нь эмэгтэй хүүхэд байна.

Иймд хуулийн төсөлд асран хамгаалах, харгалзан дэмжих хэлбэр, асран хамгаалуулах харгалзан, дэмжүүлэх хүнд тавигдах нөхцөлийн тодорхой болгож, асран хамгаалах, харгалзан дэмжих асуудлыг нарийвчлан зохицуулж, үүрэг хариуцлагын тодорхой болголоо.

Асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй болсон хүнийг илрүүлэх, бүртгэх, аль төрлийн асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт хамруулах асуудлыг дэлгэрэнгүй, нарийвчлан зохицууллаа.


Түүнчлэн асран хамгаалалт, харгалзан дэмжлэгийн харилцаанд төрийн байгууллага үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, тэдгээрийн эд хөрөнгийг хамгаалах зохицуулалтыг тусгалаа.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний нэг төсөл болох эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлж буй гэр бүл (Foster family/асралт гэр бүл)—ийн харилцаа байхыг энэ хуулиар хүлээн зөвшөөрч, уг харилцааг гэрээгээр зохицуулах, асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүүхдийн эд хөрөнгийг зарцуулах, хамгаалах, тэтгэмж, тэтгэлэг түүнтэй адилтгах орлогыг зарцуулалтад хяналт тавих зэргийг энэхүү хуулийн төслөөр зохицуулахаар тусгасан бөгөөд бусад нарийвчилсан зохицуулалтууд Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хэрэгжихээр тусгалаа.

Есдүгээр бүлэг Үрчлэлт

Иргэний бүртгэлийн байгууллагын мэдээллээр 2017 оноос 2022 оны 3 дугаар сар хүртэл хугацаанд 7596 хүүхэд дотоодод үрчлүүлсэн бол Монгол Улсын харьяат нийт 274 хүүхэд гадаадын иргэдэд үрчлэгдсэн байна.

Зураг 5.



Шүүхийн шийдвэрийн цахим сангаас, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон 2017- 2021 оны шүүхийн шийдвэрүүдийг авч үзэхэд, 2017 онд 97 шүүхийн шийдвэр, 2018 онд 12 шүүхийн шийдвэр, 2019 онд 11 шүүхийн шийдвэр, 2020 онд 12 шүүхийн шийдвэр, 2021 онд 9 шүүхийн шийдвэр байв. Эдгээр шүүхийн шийдвэрээс 2018-2021 оны шүүхийн шийдвэрүүдийг хамруулж, хүүхэд үрчилснийг ямар үндэслэлээр шүүх хүчингүйд тооцсоныг тодруулахад:

-2018 онд нийт 12 шүүхийн шийдвэрээс 11 буюу 91.6 хувь нь Гэр бүлийн тухай хуулийн 61.2-т заасан “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож, 1 шүүхийн шийдвэр нь хэргийг хэрэгсэхгүй болгосон;

-2019 оны нийт 11 шүүхийн шийдвэрээс 9 буюу 81 хувь нь мөн “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож, 1 шүүхийн шийдвэр нь хэргийг хэрэгсэхгүй болгож, үлдсэн 1 шүүхийн шийдвэрээр хэргийг түдгэлзүүлсэн;

-2020 онд нийт 12 шүүхийн шийдвэрээс 3 шүүхийн шийдвэр нь Гэр бүлийн тухай хуулийн 61.1¹⁹-т заасан үндэслэлээр, үлдсэн 9 шүүхийн шийдвэр буюу 75 хувь нь “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож шийдвэрлэсэн;

-2021 онд 9 шүүхийн шийдвэрээс 1 нь Гэр бүлийн тухай хуулийн 57.2²⁰-т заасан үндэслэлээр шийдвэрлэж, 1 шүүхийн шийдвэр нь хэргийг хэрэгсэхгүй болгож, үлдсэн 7 шүүхийн шийдвэр буюу 77 хувь нь “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож тус тус шийдвэрлэсэн үзүүлэлт гарсан.

Дээрх мэдээллээс үзэхэд, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон 2018-2021 оны шүүхийн шийдвэрүүдийн дийлэнх нь Гэр бүлийн тухай хуулийн 61.2-т заасан “бусад үндэслэл”-ээр үрчлэлтийг хүчингүйд тооцсон байна. Нийт түүвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдээс авч үзэхэд “бусад үндэслэл”-ээр гэдэгт дараах үндэслэлийг нэхэмжлэлийн шаардлагад дурдсан байв. Тодруулбал, гадаад улсад ажиллаж сурч ирээд хүүхдээ өөр дээрээ буцааж авах болсон, эцэг, эх нь хүүхдээ

¹⁹ 61.1.Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан, энэ хуулийн 57.2-т заасан этгээд болох нь илэрсэн тохиолдолд төрүүлсэн эцэг, эх, сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн өөрийн нэхэмжлэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно.

²⁰ 57.2.Ганц бие, бусдын асрамжид байгаа 60-аас дээш настай төрөл, садан бус Монгол Улсын иргэн, 60-аас дээш настай гадаадын иргэн, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн болон хорих ял эдэлж байгаа хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.

өөрийн асрамжид авах болсон, үрчлэгч өндөр насанд хүрсэн, эсхүл нас барсан зэрэг шалтгаан багтана.

Иймд хуулийн төсөлд хүүхэд үрчлэлтийн мэдээллийн сан хөтлөх, бүртгэх, хянах, үрчлүүлэх санал, дүгнэлт гаргах эрх бүхий дотоод, гадаад үрчлэлтийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл байгуулах, тус Зөвлөлийн саналыг үндэслэн үрчлүүлэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэх шинэ зохицуулалтыг тусгалаа.

Үрчлэлтийг шүүх шийдвэрлэх зохицуулалттай уялдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай болон Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд тус тус өөрчлөлт оруулж, хуулийн төслийн боловсрууллаа.

Аравдугаар бүлэг Олон улсын шинжтэй гэр бүлийн харилцаанд хэрэглэх хууль тогтоомж

Зөрчилдөөний хэм хэмжээ²¹

1998-2016 оны хооронд Монгол Улсын 5970 иргэн гадаадын иргэдтэй гэр бүл болсон бол 1017 иргэн гэрлэлтээ цуцлуулсан байна. Тухайлбал, 2022 онд 367 иргэн гадаадын иргэнтэй Монгол Улсад гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Гэр бүлийн асуудлаар явуулсан судалгаанд оролцогчдын 46.2 хувь нь даяаршсан нийгэмд гадаад хүнтэй гэрлэхийг байх л асуудал гэж үзэж байгаа нь цаашид гадаадын иргэнтэй гэрлэх гэрлэлтийн тоо нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Гэтэл практикт гадаадын иргэнтэй гэр бүл болох, гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, тэтгэлэг, хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд олон улсын чиг хандлага, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцсэн эрх зүйн оновчтой зохицуулалт хангалтгүй байна.

Иймд хуулийн төслөөр Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гэрлэлт батлуулах, гадаад улсад гэрлэлт батлуулах, дуусгавар болгох, эдгээрийн эд хөрөнгө, эцэг, эх, хүүхдийн харилцаа, эцэг, эх тогтоох, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, гадаад улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх, тэдэнд тавих хяналт зэрэг асуудлыг дэлгэрүүлж, аль улсын эрх зүйн хэм хэмжээг сонгох хэрэглэх эсэхийг талууд өөрсдөө шийдвэрлэх боломжийг сонголттойгоор бүрдүүллээ.

Арван нэгдүгээр бүлэг Бусад зүйл

Арван нэгдүгээр бүлэг Гэр бүлийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан.

Мөн энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тэтгэлэг тогтоолгосон шүүхийн шийдвэрийг тэтгэлэг авагч тал, түүний хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн авах арга хэмжээний талаар зохицууллаа. Түүнчлэн гэрлэх нөхцөлд

²¹ Зөрчилдөөний хэм хэмжээ нь асуудлыг шууд шийдвэрлэдэггүй, зөвхөн тухайн тохиолдолд ямар улсын хууль тогтоомжийг хэрэглэх вэ гэдгийг тодорхойлж өгдөг бөгөөд үүгээрээ бусад эрх зүйн хэм хэмжээнээс ялгагддаг. Гадаадын элемент бүхий иргэний эрх зүйн харилцааны үед зөрчилдөөний асуудал байнга гарч ирдэг бөгөөд, хэргийг шийдэж буй шүүхийн оршин байгаа нутаг дэвсгэрийн хуулийг хэрэглэх үү, эсхүл гадаадын хууль, өөрөөр хэлбэл хэлэлцэгдэж буй хэргийн гадаадын элемент холбогдолтой улсын хуулийг хэрэглэх үү гэдгийг шийдвэрлэх нь уг хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

тусгасан ДНХ-ийн шинжилгээ авах зохицуулалт хэрэгжих хугацааг тодорхой болгож шилжилтийн үеийн зохицуулалтыг боловсрууллаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүх шийдвэрлэсний дараа шүүх өөрөө улсын бүртгэлд энэ талаарх мэдээллээ хүргүүлэх зохицуулалтыг Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр бий болголоо.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр эвлэрүүлэн зуучлагч сэтгэлзүйч оролцуулж гэрлэгчдэд зөвөлгөө өгөх, гэрлэлт цуцлалтын үр дагаврыг тайлбарлах зэргээр дэмжлэг үзүүлэх чиг үүргийг нэмлээ.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүүхдийн хуваарьт хөрөнгийг эцэг, эх нь түүний эрх ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах талаар, хэрэв зөрчвөл учирсан хохирлыг нөхөн төлөхөөр, мөн гэрлэгчдийн дундын өмчийг хуваахдаа харгалзах зарим нөхцөл, тухайлбал гэр бүлээс гадуурх харилцааны улмаас гэрлэлт цуцлах, өр төлбөрийн хэмжээг харгалзахаар тусгав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гэрлэлтийн гэрээний зүйл үл хөдлөх эд хөрөнгө бол урьдчилсан тэмдэглэлд бүртгүүлэх харилцааг тусгалаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эх хүүхэдтэй уулзах үүргээ биелүүлээгүй, мөн уулзах үүргээ биелүүлэхэд саад учруулсан бол зөрчилд тооцохоор тусгалаа.

Хүүхэд хамгааллын тухай хуульд асран хамгаалалт, харгалзан дэмжлэг шаардлагатай хүүхдийг асралт гэр бүлд шилжүүлэхтэй холбоотойгоор нэмэлт орууллаа.